

“ГОЛОМТ” ХИЙГЭЭД “ГОЛОМДОХ”-ЫН УЧИР

Ж.Ганбаатар¹

Монгол хэлний үгийн бүтцийг ажиглахад содон сондгой зарим үг миний анхаарлыг ихэд татдаг юм. Тэдгээрийн нэг бол яах аргагүй “голомт” хэмээх үг, түүний бүтэц дэх нэрээс нэр үг бүтээдэг гэгдэх “-мт” дагавар болно. Үг бүтээх дагаврыг бүртгэн судалсан эрдэмтэд монгол хэлэнд нэрээс нэр үг бүтээх (denominal nominal suffix) –мт дагавар байна хэмээгээд “голомт” гэдэг ганцхан үгээр жишээ татсан байдаг. Үүнээс улбаалаад монгол хэлний үгийн сангаас нэр язгуур бүтээвэрт –мт дагавар залгаж бүтээсэн өөр үг олох эрэлдээ мордлоо. Урьд өмнө хэвлэгдсэн монгол хэлний үгийн бүтцийн судалгаа, томоохон толь бичгүүдийг шүүсэн боловч “голомт”-оос өөр тохиолдол олсонгүй. Түүнээс хойш энэхүү “голомт” гэдэг үгийн талаар юм бичье хэмээн санаж, судалгаа шинжилгээний бүтээл, утга зохиолын ном судраас түүнтэй холбоотой жишээ баримт цуглуулж эхэлсэн юм. Ер нь голомт гэдэг үгийн язгуур гэгдэх “гол” чухам юуг зааж байна, тухайн үгийн язгуур мөн үү, биш үү гэдэг нь эргэлзээтэй хэвээр байна. Орчин цагийн монгол хэлний хүрээнд тухайн үгийн уг язгуурыг нь тогтоох бараг боломжгүй болжээ. Үгийн бүтцийн үүднээс гол-(u)mta юм уу, гол-(u)mta уу, эсвэл голum-ta юм болов уу?

“Голомт” гэдэг үгийг судлаачид “гал” болон “гол” (төв хэсэг)-той тус тус холбон тайлбарладаг. Академич Л.Болд энэ үг “...лавтайяа гал гэдэг үгтэй холбоотой...”², судлаач Г.Хайрхан “гал гэдэг үгнээс авиа сэлгэх аргаар үүссэн үг”³ гэж үзсэн бол, өвөрмонголын судлаач Норжин “голын байр”⁴ гэсэн үг гээд монгол бичгээр “ голumta ” гэж бичих санал дэвшүүлсэн байдаг. Үнэхээр “гол” (төв, дунд) гэсэн үг бол монгол бичгээр “ голumta ” (ᠭᠣᠯᠠᠮᠲᠠ) гэж бичих ёстой. Гэтэл өнөөг хүртэл яагаад “ голumta ” (ᠭᠣᠯᠠᠮᠲᠠ) гэж бичсээр ирэв? Үүний цаанаа бас нэг нууц агуулагдаж буй мэт. Монгол бичгийн гол (гол) гэдэг үгийн бичлэгийн тухайд дүрсээр утга ялгахын тулд зориуд хоёр о эгшгийг дараалуулан бичсэн байж болзошгүй.

Эцгийн гэрээс гал тасран, өрх тусгаарлах зан үйлтэй холбоотой “голомт тулах” (айл гэр болох), “голомт үүсгэх” (гэрлэх), “голомтоо бадраах”, “голомт залгах”, “голомт сахих”, “эцгийн голомт” зэрэг хэллэг байдаг. Эцэг өвгөдийн гэр, галыг залгамжлан яваа айл өрхийг зааж буй өмнөх хэллэгүүдэд гал, голомт хоёр утгын нягт холбоотойг тодруулж өгч байна. Харин “гал тасрах” гэвэл өрх тусгаарлан айл гэр болохыг хэлдэг бол, “голомт тасрах” нь үе залгамжлах хүнгүй болох гэсэн санааг илэрхийлж буйгаараа л утгын зөрөөтэй байна. “Дайны голомт”, “халдварын голомт”, “тахлын голомт”, “соёлын голомт” зэрэг “төв, үүр, үүсгэвэр” гэсэн утга нь “гал”-ынхаас арай хожуу салбарлан үүссэн утга шиг байна.

Голомттой холбоотой өмнөх хэллэгүүд нь “гал” болон “гол” (төв хэсэг)-той утгын холбоотой байна. Харин

1. ШУА, Хэл Зохиолын Хүрээлэн

2. Л.Болд. Орчин цагийн монгол хэлний дагавар. УБ., 1986. х.76.

3. Г.Хайрхан. Монгол хэлний голомт гэх үгийн тухай – “Монгол судлалын чуулган” №12 (47), УБ., 2012. х.63.

4. Норжин. Монгол хэлний үг бүтээх дагаврын хураангуй. ӨМСХХХ, 2001. х. 100.

- “голомт цайх” (мөхөх, үндсээрээ сүйрэх),
- “голомтыг нь хийсгэх” (орон гэргүй болгох, гэр орны нь сүйтгэх),
- “голомтыг нь самрах” (а. Бусниулан түйвээх б. Айл гэрийн үр удмыг таслах),
- “голомтоо самруулах” (өрх гэрээ түйвээлгэх)
- “голомтоороо шуурах” (үндсээрээ сүйрэх)
- “голомт баллах” (үе угсаагаар нь сүйтгэх),

зэрэг нь “гал” болон “гол”-ын аль алинтай утгын шууд холбоогүй байгаа нь миний анхаарлыг татлаа.

Мэдээжийн хэрэг “гал”, “гол”-ыг хийсгэж, самарч, бас цайруулж (цагаан болгож) болохгүй. Тиймээс “голомтыг нь хийсгэх”, “голомтоороо шуурах”, “голомтоо самруулах”, “голомт цайх” зэрэг хэлц хийсвэр зүйлийг бус, харин ямар нэгэн бодит юм үзэгдлийг заагаад байх шиг. Эдгээр хэллэгийн ард “голомт” гэдэг үгийн жинхэнэ уг язгуур, мөн чанар нуугдаж байгаа юм биш биз.

Нэрээс нэр үг бүтээх –мт дагавар авч бүтсэн үг хайх явцдаа “голомт”-той нэг язгууртай байх магадлалтай “голомд-” (yolumda-) гэдэг үг олсон юм. Эл үгийг профессор Ш.Чоймаа нар “түүхий юмыг нурманд шарах”⁵ гэж тайлбарлажээ. Дээрх тайлбараар “голомдох” нь “нурамлах” (нурманд булаж болгох) гэсэн үгтэй утга яг таарч байна. Тэгэхээр голомт, нурам хоёрын хооронд ямар нэгэн холбоо хамаарал байж болох юм.

Шатсан бодисоос үлдэх органик биш нунтаг саарал зүйлийг “үнс нурам” гэдэг. Хэрвээ голомтыг нурамтай холбоотой гэж үзвэл “голомт цайх” гэдэг хэллэг нь “сүйрч (шатаж) үнс нурам болох” гэдэгтэй үндсэндээ тохирч байна. Цаашлаад “үнс нь хийсэж, өрх нь харлах” (мөхөх, сүйрэх, үндэс угсаа тасрах), “үнсийг нь хийсгэх” (гэр орон гал голомтыг нь бусниулах), үнсээр хийсгэх (юу ч үгүй болгох, хүйс тэмтрэх, устгах) зэрэг нь “голомтыг нь хийсгэх”-тэй дүйнэ. Түүнчлэн “голомтыг нь самрах”-ын нэгэн адил айл гэрийн “үнсийг самарч” (ийм хэллэг хайсан боловч олсонгүй) болно. Эндээс голомт, нурам (халуун үнс) хоёр утгын хувьд холбоотой болох нь тодорхой харагдана. Харин гарлын талаасаа ямар нэгэн холбоо байна уу.

Бичгийн зарим томоохон дурсгалаас хайхад “Монголын нууц товчоо”⁶, “Мухаддимат ал адаб толь”⁷-ны хэлэнд голомт гэдэг үг энэ хэлбэрээрээ хэрэглэгдэж байжээ. Түүнчлэн монгол хэл аялгуунуудын хүрээнд голомт (yolumta)-ыг үгийн гарлын үүднээс нурам (nurma), үнс (ünesü)-тэй холбох сэжиг, гарлыг нь тогтоох боломж олдеонгүй. Тиймээс монгол хэлтэй төрөл төс алтай язгуурын хэлнүүдээс голомт, үнс нурам гэдэг үгсийг шүүн үзье.

Голомт гэдэг үг хэлбэрээрээ гүрэг хэлнүүдэд байна. Турк, казак хэлэнд “коламга” (горячая зола), киргизээр “коломто”⁸ (очаг в юрте для приготовления пиши: место в юрте, на котором разводится огонь), якутаар “холмужан” (очаг у каминна, место для разведения огня), уйгараар “колун” (передняя часть очага, топка)⁹ гэдэг талаар эрдэмтэд тэмдэглэн үлдээжээ. Эндээс харахад утга агуулгын хувьд ч, гарлын талаасаа ч “голомт” нь дан ганц монгол хэлний үг бус алтай язгуурын хэлнүүдийн дундын шинжтэй үг шиг санагдана.

Алтай язгуурын хэлний томоохон төлөөлөгч болох эргний гүрэг хэлэнд күл¹⁰, эдүгээгийн казак, киргиз, якут хэлэнд күл¹¹ гэж үнс, нурмыг заасан үг байна. Түрэг хэлнүүдийн күл (үнс

5. “Монгол хэлний хэлзүйн толь бичиг”¹ боть. УБ., 2005. х.193. (Жич. Бусад толь бичгээс “голомдох” гэдэг үг олсонгүй).

6. qolumta – 中火城, 塔、火盤(02:10:03, §77), *豁魯, 塔、火盤 (10:40:06, §245) – “Word-Index to the Secret History of the Mongols with Chinese Transcriptions and Glosses”. Compiled by Hitoshi Kuribayashi. Sendai., 2009. p.392.

7. yolumtan (fireplace). The Mongolian Words in the Muqaddimatal-Adab: Romanized Text and Words Index. Tokyo, 2008. Text.31.

8. Киргизско-русский словарь I. Сост. К.К.Юдахин. Фрунзе., 1985. х.398.

9. Номинханов Ц-Д. Материалы к изучению истории калмыцкого языка. М., 1975. х.146-147.

10. Күл - зола. Древнетюркский словарь. Ленинград. 1959.х.325.

11. Күл-зола. пепел. күл болу → обратиться в пепел, күл салгыш → пепельница. (<http://sozdik.kz/ru/dictionary/translate/kk/ru/күл/>); Күл– үнс. Аргалын үнс – тезек күл (Б.Базилхаан. Монгол - казак толь. Өлгий, 1984. х.536);

Күл - зола, пепел (Киргизско-русский словарь I. Сост. К.К.Юдахин. Фрунзе., 1985. х.462).

нурам) нь монгол хэлний *ᠶolumta* гэдэг үгийн язгуур гэгдэх “*ᠶol*” -той холбоотой нь маргаангүй аж. Алтай язгуурын зарим хэлэнд үнс нурмыг *kor(kop)*¹², *koz* (коз)¹³, *kūz* гэж хэлдэг нь монгол, түрэг хэлний *l – r* авиа, *r – z* авиа тус тус сэлгэдэг зүй тогтолтой холбоотой.

“Монголын нууц товчооны” хэлэнд *qolumta* [*火爐_木塔、火盤 (02:10:03, §77), *豁魯_木塔、火盤 (10:40:06, §245)]¹⁴ хэлбэрээр гарч байгаа учир язгуур нь **qol* байж болно. Монгол хэлний ойрад аялгуунд *ᠶulumta*¹⁵, буриад аман аялгуунд¹⁶, Говь-Алтай, Баянхонгорын халхын аман аялгуунд *ᠶulamta*¹⁷ гэж байгааг харгалзан эртний хэлбэрийг нь **ᠶul*/**qul* гэж сэргээж болно. Ингэж үзвэл **qul* –ын эм эгшгээр амилсан хэлбэр нь **kūl* буюу “үнс нурам” болно. Алтай язгуурын хэл болоод монгол төрөл хэлнүүдэд *q ~ ᠶ ~ k* гийгүүлэгч харилцан сэлгэдэг.

Дээр дурдсанчлан одоогийн монгол хэлний үгийн сангаас нэр язгуур, үндсэнд –*mt* дагавар залгаж үг бүтээсэн “голомт”-оос өөр тохиолдол олдсонгүй. Тиймээс судлаачдын монгол хэлэнд нэрээс нэр үг бүтээдэг –*mt* дагавар бий гэдэг санал эргэлзээ төрүүлж байна.

Харьцуулсан судалгааны үр дүнд голомт гэдэг үгийн язгуурыг **kūl* гэж тогтоолоо. Монгол хэлэнд нэр язгуур, үндсэнд залгаж *ogu-m* (мөр), *jisū-m* (малын) гэх мэтээр ихэвчлэн тэмдэг нэр бүтээдэг –*m* (*m*) дагавар бий. Энэхүү дагавар нь *qul(*kūl) – (u)m* гэж үг бүтээх боломжтой. Монгол хэлний –*m* дагавар утга болоод байрын хувьд ардаа “орны” утгатай –*t* (*-tu, -tū*) дагавар авдаг. Эндээс *qul–(u)m–tu* болно. Голомт гэдэг үг нь дээрх хэлний хөгжлийг туулсны үр дүнд бүтсэн үг болов уу гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Эрт цагт “голомт” –ын **kūl* язгуур нь халуун үнс нурмыг, **qulum*/**ᠶolum* нь гал түлсэн газрын шатаж харласан ормыг, *ᠶolumtu, mo, ᠶolumta* (-*t* дагавар нь харганат, зээргэнэт, харзат, шарилжит гэх мэт орны утгат нэр үүсгэдэг) нь үнс нурам бүхий тулга зуухны орчим газрыг заадаг байсан ажээ. Цаашлаад голомт нь эцэг өвгөдийн гал, гэр, түүнийг залгамжлан яваа хүн, айл өрхийг нэрлэдэг болсон байна. Хожим үндсэн утгаас “үүр, үүсвэр, уурхай” зэрэг утга салаалан хөгжжээ.

12. Кор - горячая зола. Киргизско-русский словарь I. Сост. К.К.Юдахин. Фрунзе., 1985. х.405.

13. Коз - (халуун үнс) нурам; коз га көмп тастау - нурманд булж орхих. Б.Базилхаан. Казак-монгол толь. УБ., 1977. х.185.

14. “Word-Index to the Secret History of the Mongols with Chinese Transcriptions and Glosses”. Compiled by Hitoshi Kuribayashi. Sendai., 2009. p.392.

15. Ж.Цолоо. БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. II (ойрд аялгуу). УБ., 1988. х.361.

16. Г.Гантогтох. Буриад аялгууны толь. УБ., 2010. х.155.

17. Б.Амаржаргал. БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. I (халх аялгуу). УБ., 1988. х.162.

АШИГЛАСАН НОМ, ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. Амаржаргал Б. БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. I (халх аялгуу). УБ., 1988.
2. Базилхаан Б. Казак - монгол толь. УБ., 1977.
3. Базилхаан Б. Монгол - казак толь. Өлгий, 1984.
4. Болд Л. Орчин цагийн монгол хэлний дагавар. УБ., 1986.
5. Гантогтох Г. Буриад аялгууны толь. УБ., 2010.
6. Древнетюркский словарь. Ленинград. 1959.
7. Киргизско-русский словарь, II. Составил проф. К.К.Юдахин. Фрунзе., 1985.
8. "Монгол хэлний хэлзүйн толь бичиг" I, II боть. УБ., 2005.
9. Номинханов Ц.Д. Материалы к изучению истории калмыцкого языка. М., 1975.
10. Норжин. Монгол хэлний үг бүтээх дагаврын хураангуй. ӨМСХХХ, 2001.
11. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Дэд дэвтэр. УБ., 1966.
12. Хайрхан Г. Монгол хэлний голомт гэх үгийн тухай – "Монгол судлалын чуулган" №12 (47), УБ., 2012. х.61-67.
13. Цолоо Ж. БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. II (ойрд аялгуу). УБ., 1988.
14. The Mongolian Words in the Muqaddimat al-Adab: Romanized Text and Words Index. Tokyo.2008.
15. 「元朝秘史」モンゴル語漢字音訳・傍訳漢語対照語彙」東北大学東北アジア研究センター、2009年、538頁。
16. <http://sakhatyla.ru>
17. <http://sozdik.kz>

ABSTRACT

In this article, the etymology of Mongolian word "γolomt" is studied. This word has been analyzed from linguists point of view. The structure of γol-(u)mta and word root has been explained in connection with "γal" (fire) and "γol"(center) meanings. As a result of this study, it is ascertained that the word root is *kūl.

In earlier time, *kūl root shows hot ash, *kūlūm/*qulum/γolum means the burned trace of fire, γolumtu (mo.γolumta) shows the place around ashy stove. Furthermore, "γolomt" named fire, home, heir and family of the ancestor. Later, it means as "spot, nucleus, formation", which is developed from main word.